



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 171

Мандалговь

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг тус тус үндсэлэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Дэрэн сумын 9 жилийн дунд сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 34'913'750 /гучин дөрвөн сая есөн зуун арван гурван мянга долоон зуун тавь/ төгрөгийн анхны өртөгтэй, 2'054'092 /хоёр сая тавин дөрвөн мянга ерэн хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй бага сургууль, дотуур байрны барилгуудыг данс бүртгэлд хэвээр үлдээж, зориулалтыг өөрчлөн, сэргээн засварлаж эзэмшихийг Дэрэн сумын 9 жилийн дунд сургуулийн захирал П. Ганаад даалгасугай.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 сарын 14-ний өдрийн 158 тоот “Хөрөнгө данснаас хасах тухай” тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100352